



ДУНДГОВЬ АЙМАГ
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А/239

Мандалговь

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь заалт, Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.5 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. “Сүлд морь” ХХК (РД:2012332) нь сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт байршилтай ойжуулалтын зориулалттай 576000 м.кв (57.6 га) газрын төлбөрөө хугацаанд нь төлөөгүй мөн 2020 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 05 дугаар албан бичгээр газар эзэмших эрхийг цуцлуулах тухай хүсэлт ирүүлсэн тул газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгож, газар эзэмших эрхийг дуусгавар болгосугай.

Хоёр. Дээрх аж ахуйн нэгжийн газар эзэмших гэрээг цуцалж, гэрчилгээг хүчингүй болгохыг Газрын даамал (Л.Хулан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА С.БАТ-ОРГИЛ

